

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн Засаг дарга О. Амгаланбаатарын санаачилгаар Үндэсний бичгийг кирилл үсэгтэй хослуулан төрийн албан хэрэг хөтлөлтөд нэвтрүүлэх ажлыг эхлүүлж байна. Уг ажлын хүрээнд хосолсон бичигтэй хэвлэмэл хуудсыг албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарт гардуулан өгч, 2021 оныг үндэсний бичиг үсгээ дээдлэх, сурах, хэрэглэх өвлүүлэх жил болгон зарлаж, 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шат дараатайгаар монгол бичгийн хичээлийг тусгай хөтөлбөрийн дагуу төрийн албан хаагчдад заахаар шийдвэрлэлээ. Албан байгууллага аж ахуй нэгжийн хаягийг стандартын дагуу шинэчлэх, албан хэрэг хөтлөх хэвлэмэл хуудсыг хосолмол бичгээр хэвлүүлэх, Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зэрэг байгууллага хамт олноороо Монгол бичигтэн болох ажлуудыг шат дараатай хийхээр төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын албан хаагчид болон салбар бүрийн төлөөллүүдтэй уулзан бодлогын тэргүүлэх чиглэл, 2021-2024 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг танилцуулж, санал бодлоо солилцсон бөгөөд сумдын төрийн албан хаагчид уг уулзалтад цахимаар оролцлоо.

Төрийн албаны зөвлөлөөс салбар зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагийн холбогдох албан тушаалтнуудад 6 удаагийн цахим сургалтыг зохион байгууллаа.

Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрүүдэд www.csc.gov.mn цахим хаягаар бүртгэн, төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр 314 иргэн бүртгүүлээ.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ, хэрэгжилтийг байршууллаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн 08 дугаар хурлаар хэлэлцүүлэн, хэрэгжилтийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2020 оны захирамж, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүллээ.

Үйлчилгээний нэгдсэн төв нь иргэдээ сонсох нээлттэй утас 70481111, мэдээлэл лавлагааны E-Mongolia цахим үйлчилгээ, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Архивын тасаг, Наториатын үйлчилгээгээр нийт 162 нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 2100 иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээс түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэлээ.

Иргэдээс нийт 11 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирснээс 5 өргөдлийг шийдвэрлэж, 6 өргөдөл нь хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт нь 45.5 хувьтай байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл гомдол байхгүй. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног байна.

2021 оны 1 дүгээр сард бүртгэгдэж, хяналтын хугацаа сунгагдан шийдвэрлэлт нь хойшлогдсон 2 өргөдөл байна. Үүнээс төсөв санхүүтэй холбоотойгоор шийдвэрлэлт нь хойшлогдон судлагдаж байгаа 1 өргөдөл байна.

“Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111” дугаарын утсанд 02 дугаар сарын байдлаар нийт 46 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгч E-OFFICE программд бүртгэгдсэн 24 гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагуудад шилжүүлэн хяналт тавин шийдвэрлүүлээ. Хугацаандаа судлагдаж байгаа 15 өргөдөл, шийдвэрлэлт 37.5 хувьтай байна.

E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээр 9 төрлийн төлбөртэй лавлагааг 90 иргэнд, төлбөргүй олгогддог 34 лавлагаа, нийт 124 лавлагаа мэдээлэл гаргасан ба WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамж 142.5 мянган төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга 77 захирамж гаргаж, 51 захирамжийг карталж, хяналтад аван хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Алтай, Дарив, Эрдэнэ, Хөхморьт сумдын Засаг даргын гаргасан нийт 27 захирамжийн эрх зүйн үндэслэл, Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, баримт бичгийн стандарт хангасан эсэхийг хянаж, зөвлөмж хүргүүлээ.

“Гэрээ хянах, бүртгэх журам”-ыг боловсруулан, аймгийн Засаг даргын захирамжаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлэх үүрэг бүхий 241 мэдүүлгийг бүрэн бүртгэж, хянаж хүлээн авлаа.

Тайлант хугацаанд 2020 онд шинээр томилогдсон 25 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хүлээн авч бүртгэн хянан баталгаажуулж, ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн 180 мэдэгдэл, хувийн ашиг сонирхлын 44 урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч цаасаар болон цахимаар бүртгэж ажиллалаа. Мөн 2021 онд АТГ-ын Олон нийтийн төвөөс зохион байгуулах авлигын эсрэг сургалтад хамруулах албан хаагч нарын судалгааг сум, агентлагуудаас авч, нэгтгэн хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “ХАСХОМ-1” , “ХАСХОМ хураангуй” тайлан мэдээг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст албан бичгээр хүргүүлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж буй 5 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим системд бүртгэж, мэдүүлэгт заасан холбогдох материалыг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс хянуулахаар хүргүүлээ.

Улс, орон нутгийн тусгай сангуудын гэрээний хэрэгжилт хангалтгүйгээс өр төлбөр нэмэгдсэн асуудал үүссэнтэй холбогдуулан Шүүхийн шийдвэртэй өр төлбөрийг хугацаанд нь барагдуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг байгуулан, өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлж байна.

Архивын тасаг: Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 55 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 680 хуудас бүхий

лавлагаа олгож, Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 592.5 мянган төгрөгийн хураамжийг төрийн сангийн орлогын дансанд төвлөрүүлээ.

Чандмань сумын “Үүрийн туяа” нэгдлийн 1962-1989, 1991 оны 68 хадгаламжийн нэгжийг иж бүрэн нягтлан шалгаж, баримт бичгийн дараалалд оруулан, хуудас дугаарлах, хамгаалах хайрцганд хийх, хөмрөгийн дугаар, хадгаламжийн дугаар, нэгжүүдийг болон хуудас дугаарлах, оны хязгаарыг бичиж байрлууллаа.

3 хөмрөгийн 8 хадгаламжийн нэгжийн 5612 хүний нэрийг тодорхойлон бичиж, 8 хадгаламжийн нэгжийн 1131 хуудас баримтыг цахим холболт хийж, 7711 хуудас баримтыг засварлаж сэргээлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд явуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчиллээ.

Тайлант хугацаанд иргэний бүртгэлийн 229 лавлагаа гаргаж, 12 иргэний гадаад паспортын захиалга авч, 12 хуулийн этгээдийг шинээр, 10 хуулийн этгээдийг дахин бүртгэн гэрчилгээ олгож, бүртгэлийн цахим мэдээллийн санг тухай бүр баяжуулсан.

Иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 335 мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн, иргэд, хуулийн этгээдээс бүртгэлийн үйлчилгээний хураамж 5127.2 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Тайлант хугацаанд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 15 иргэнд 300.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, зөрчлийг арилгууллаа.

Шүүхийн шинжилгээний алба: Шүүх эмнэлгийн 37 шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, 95 объектын шинж тэмдгийг бэхжүүлж, зураг авлаа.

Эрүүгийн хэргийн 15 тусгай шинжилгээ хийснээс химийн 9, биологийн 6 шинжилгээ хийсэн байна.

Мөн эрүүгийн хэрэгт 1 криминалистикийн шинжилгээ хийж, хэргийн газрын үзлэгт 19 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 5, хулгай 2, хүчин 1, зам тээврийн ослын 8, бусад 3 хэрэгт тус тус үзлэг шинжилгээ хийлээ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эхний 2 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 1236.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1355.8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 109.4 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 240.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 277.3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 115.2 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 1265.0 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 2853.2 сая төгрөгийг бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг бүрэн олголоо.

ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/35 дугаар захирамжаар аймгийн аварга малчин, тариаланч, хадланчаар шалгарсан малчид, тариаланчдын шагналыг гардуулан өглөө.

Дэлхийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслөөс Бигэр, Бугат, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Халиун, Чандмань, Цогт, Цээл, Эрдэнэ сумдын 4.2 мянган малчин өрхөд 1.1 тэрбум төгрөгийн хүчит тэжээлийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэж, 02 дугаар сард 2-р ээлжийн 300 тн тэжээлийг хүлээн авч сумдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд том малын зүй бус хорогдлын мэдээг сумдаас авч нэгтгэн ХХААХҮ-ийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтэст хүргүүлж байгаа бөгөөд нийт мал сүргийн 1.1 хувь буюу 35.8 мянган толгой мал зүй бусаар хорогдсон байна.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Удирдлагын Академийн хамтарсан цахим сургалтад 2 албан хаагч, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан сургалтад сумдын Хөдөө аж ахуйн тасгийн газар тариалан хариуцсан мэргэжилтнүүд тус тус хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоног бүр, Түүхий эдийн ханшийн мэдээг сумдаас авч нэгтгэн ХХААХҮ-ийн яаманд тус тус хүргүүллээ.

Мөн Говь-Алтай үүлдрийн хонь, Төхөм тунгалгийн хүрэн үүлдрийн тэмээний стандартын шаардлага хангасан өсвөр хээлтэгч, хээлтүүлэгчийн судалгааг гаргаж Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүллээ.

Мал эмнэлгийн чиглэлээр: Тайлант хугацаанд 9233 мал, 13 тонн мах, 18157 арьс шир, 120 литр сүү, 26 мал эмнэлгийн цахим гэрчилгээ олгогдлоо.

Бигэр сумд үхрийн энтериобактериоз, Шарга сумд тэмээний галзуу, Тайшир сумд ямааны хамуу өвчин оношлогдож, сумдын Засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоон, тус өвчнүүдтэй тэмцэх зааврын дагуу ажиллаж байна.

Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй Хөлөг, Андууд цайны газрын 100 кг махны 2 дээжид мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олголоо.

Сумдын мал эмнэлгийн мэргэжилтнүүдэд төрийн албаны шалгалт болон хөдөлмөрийн дотоод журам танилцуулах, галзуу өвчний үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар онлайн сургалт зохион байгуулж, цаг үеийн мэдээлэл өглөө.

ТАВ. БАРИЛГА ХОТ БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Газрын харилцааны чиглэлээр: Аймгийн Засаг даргын газар эзэмших эрх шилжүүлэх шийдвэрээр 5 иргэнд орон сууцны зориулалтаар тус тус газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгууллаа. Газар эзэмшигч 3 байгууллага, 12 иргэний байршлын кадастрын зургийг гаргалаа.

2021 оны газрын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын ногдуулалтыг нэгж талбар бүрээр тулгалт хийж аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 17 сумын 5094 нэгж талбарт газрын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын нэхэмжлэлийг үүсгэлээ. Газрын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 2021 оны газрын төлбөрийн ногдуулалтыг 9 сумын 5593 нэгж талбарт хийж нэгж талбар бүрээр газрын төлбөрийн бодолтын тулгалтыг хийлээ.

2021 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг хуулийн дагуу 11459 нэгж талбарт бүрэн ногдуулалт хийж 39442 нэхэмжлэлийг газрын төлбөрийн цахим системээр үүсгэж хуулийн хугацаанд нь татварын ерөнхий газарт мэдээллийг хүргүүллээ.

Барилга угсралтын чиглэлээр: Төгрөг сумын Хаан банкны барилга угсралтын ажилд комисс ажиллан ашиглалтад, Алтай сумын Эрүүл мэндийн өргөтгөлийн барилга угсралтын ажилд захиалагчийн техник хяналт тус тус хийж гүйцэтгэлээ.

Сумдад барихаар төлөвлөгдсөн 120 айлын орон сууцны барилгын инженер геологийн судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээг бэлтгэн "Барнаб" ХХК-д хүргүүллээ.

Хот байгуулалтын кадастрын цахим систем нэвтэрсэнтэй холбоотой архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах хүсэлтийг urban.gov.mn цахим хаягаар хүлээн авч байна.

Дэлгэр сумд хэрэгжиж буй Сумын төвийн шинэчлэл төслийн барилга угсралтын ажлыг хэсэгчлэн хүлээж авах аймгийн Засаг даргын 2021 оны 02 сарын 05-ны А/47 дугаар захирамжийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсэг ажиллалаа.

Бие даасан өөрийн барилгагүй үйл ажиллагаа явуулдаг нийгмийн үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг гарган Газар зохион байгуулалт, геофизи, зураг зүйн газарт хүргүүллээ.

Тус аймагт барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 22 аж ахуй нэгжийн 2020 оны жилийн эцсийн тайланг n.enkhjargal@barilga.gov.mn цахим хаягаар хүргүүллээ.

Нийтийн аж ахуй талаар: “Ундарга-Алтай” ААТҮГ нь 3 гүний худаг, 2 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаагаа явуулж Алтай хотын ард иргэддээ 48460 м³ ус олзворлолоо.

2-р өргөлтийн насос станцын хувьд энэ жил 2 насос /№2,3/, 1 нөөцийн /№1-р насос/ насостойгоор үйл ажиллагаагаа явуулж нийт 43219 м³ усыг даралтат усан санруу шахсан ба насос станцын хлоржуулах төхөөрөмжөөр 3 удаагийн хлорыг 3.6 кг гипохлороор цэвэр усанд тавьлаа.

Цэвэрлэх байгууламжид энэ сар 43436 м³ бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 6.3 м³ усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаялаа.

Засгийн газрын 211 дүгээр тогтоолын дагуу Усны үнийн хөнгөлөлт чөлөөлтөнд хамрагдах ААН байгууллага, айл өрхүүдийн нийт 55.9 сая төгрөгийн нэхэмжлэлийг Хот суурины ус хангамж, ариутгах татуурын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд хүргүүллээ. Хөнгөлөлт чөлөөлтөд хамрагдсан 2195 айл өрхөд мессежээр мэдээлийг хүргэлээ.

Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд: Сумдад баригдах 8 блок 120 айлын орон сууцны барилгын эхний ээлжийн 15 айлын орон сууцны барилгын загвар зургийг, 17 сумын инженерийн геологийн хөрсийг шинжилгээнд өгч, нэгдсэн дүгнэлтийг Барилгын хөгжлийн төвд экспертизээр батлуулахаар тус тус хүргүүллээ.

Хөрөнгө оруулалт: Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн махны үйлдвэрийн барилга, 4 блок 37 айлын орон сууцны барилга, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 5 төсөл арга хэмжээнд тус тус улсын комисс томиллоо.

ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:

Эрүүл мэндийн салбар: “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ” сэдэвт багц цагийн цахим сургалтад хамрагдсан 196 эмнэлгийн мэргэжилтний судалгааг ЭМХТ-д хүргүүллээ.

Аймгийн хүн амын төрөлт, нас баралт, өвчлөл, хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сангийн орлогын мэдээг төрийн болон хувийн хэвшлийн 51 байгууллагаас авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төв, Гэмтэл судлалын үндэсний төвийн Тандалт судалгааны албанд, сувилагчийн ажлын байранд ажиллаж буй эмнэлгийн бусад мэргэжилтний болон сувилагчаар ажиллах хүсэлтэй нөөцөд буй эмнэлгийн

мэргэжилтний судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төвд, бага насы хүүхдийн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн нөөц, түгээлт, хэрэглээний судалгааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд тус тус хүргүүллээ. Мөн Ковид-19 цар тахалтай холбоотой цаг үеийн шаардлагаар авдаг мэдээллийг www.burtgel.mohs.mn-аар системээр нэвтрэн харъяа байгууллагаас ирүүлсэн өдөр бүрийн мэдээг тайлант хугацаанд 26 удаа хянан баталгаажуулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээлээ.

“Архидан согтуурахаас сэргийлье” цахим аяны удирдамж боловсруулан харъяа байгууллагуудад хүргүүллээ. Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн ашиглалтын судалгааг гаргаж 2021 онд ашиглалтад оруулахад шаардлагатай 8 сумын 106.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр НҮБ-ын Хүн амын санд хүсэлт хүргүүллээ.

“Дэлхийн хавдартай тэмцэх” өдрийн хүрээнд “БИ НЭГДЭНЭ БИ ДЭМЖИНЭ” уриан дор орон нутгийн радио, телевизээр live хийж, иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан "Коронавируст (КОВИД-19) халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь" сэдэвт цахим сургалтад 34 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ЭМС-ын 2021 оны А/29 дүгээр тушаалын танилцуулга цахим сургалтад сум, өрхийн ЭМТ-ийн 124 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, төсөвчний анхан шатны болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үзэл баримтлал “Алсын хараа-2050” цахим сургалтад холбогдох мэргэжилтнүүд, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах цахим сургалтад 3 албан хаагч, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, АШУҮИС-ийн ГАА дахь салбар сургууль хамтран “Судалгааны арга зүй” цахим сургалтыг зохион байгуулж, 12 байгууллагын 46 албан хаагч тус тус хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын ЭМД-аас авах төлбөрийн хэмжээ, жагсаалт баталсан ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолын танилцуулга” цахим сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын 60 албан хаагч хамрагдлаа.

Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвийн 2021 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвд 2021 онд нийлүүлэх 14 багцыг шалгарууллаа.

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 1 сарын байдлаар 107 эх нярайлж өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдол буюу 5.9 хувиар, 108 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хүүхдээр буюу 6.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нас баралтын 21 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 0.4 болж өмнөх оноос 0.1-ээр нэмэгдсэн байна. Нас баралтын 14.3 хувийг нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 28.6 хувийг хорт хавдрын шалтгаант, 23.8 хувийг осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт тус тус эзэлж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт тайлант хугацаанд 924 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 13 байсан ба нас баралтын тохиолдол гараагүй байна. Амбулаториар нийт 1682 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс томуу, төст өвчинтэй 47 тохиолдол бүртгэгдлээ. Хүүхдийн тасагт 103 ор хоногийг ашигласнаас 2 хүнд хүүхэд эмчлэгдэн эдгэрлээ. Энэ хугацаанд нийт 24 эх эсэн мэнд амаржиж 24 хүүхдийг хүлээн авлаа. Мэс заслын тасагт 18, Гэмтлийн тасагт 3, Төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 4, нийт 25 мэс заслыг амжилттай хийлээ. Түргэн тусламжийн 122 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 180 хүн өөрөө ирж үзүүлснээс 9 буюу 0.05% нь томуу, томуу төст өвчний тохиолдол байлаа. Алсын дуудлагын 3 тохиолдолд үйлчиллээ.

2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 02 дугаар сарын 28 хүртэлх хугацаанд шинжилгээнд 6053 иргэн, PCR шинжилгээнд 1188 иргэн хамрагдаж, гэрийн ажиглалтад 136 иргэн байна. Харьяа байгууллагуудад байгаа ковид-19 илрүүлэх түргэвчилсэн оношлуурын нөөц 2947 ширхэг, PCR шинжилгээний оношлуур 42 ширхэг байна.

Эрүүл мэндийн газарт 63.6 сая төгрөгийн Ковид-19 вирусээс сэргийлэх хамгаалах хэрэгслийн нөөц байгаа ба нэг удаагийн бээлий, халаад, зайнаас халуун хэмжигчийн нөөц дутагдалтай байна. Дутагдалтай байгаа хамгаалах хэрэгслийг худалдан авахад 17.5 сая төгрөгийн эх үүсвэр шаардлагатай байна.

Гэрийн ажиглалтад байгаа иргэдэд зориулан үүсгэсэн “Зөвлөгөө, сурталчилгаа” хаалттай бүлэгт эрүүл мэндийн зөвлөмж, зөвлөгөөг 23 удаа оруулж 394 иргэн хандаж, мэдээлэл авсан байна.

”Алтай мэдээ” агентлаг цахим хуудсаар 17 төрлийн мэдээлэл тавьж, 1269 хандалт авсан байна.

Миний нутаг телевиз, радио, МОНЦАМЭ агентлагт тус бүр 9 удаагийн цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэлээ.

Хөдөлмөрийн зах зээлийн талаар: Аймгийн хэмжээнд нийт 980 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд 35 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авлаа. Мөн 6 байгууллага 7 иргэнийг ажилд авахаар захиалга ирүүлж, ажлын байрны захиалгуудыг цахим хэлбэрээр иргэдэд мэдээлж, байгууллагын хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажил олгогчдод санал болгон, 2 иргэнийг ажилд зуучиллаа.

Нийгмийн халамжийн сангийн талаар: Цахим эрхийн бичгийн үйлчилгээнд 02-р сард 680 өрхийн 3465 иргэн хамрагдаж, 42472.0 мянган төгрөгийн санхүүжилт хийлээ.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 02 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 9392 иргэнд ХААН болон Төрийн банкаар 3220.6 сая төгрөг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан өндөр настан 32, тахир дутуу 13, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 3, нийт-48 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тайлант хугацаанд Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 54 хүнд 96.9 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 19 хүнд 1.9 сая, оршуулгын тэтгэмж 6 хүнд 6.0 сая, ажилгүйдэлийн тэтгэмж 36 хүнд 30,6 сая төгрөгийг тус тус олголоо. Сайн дурын даатгалд нийт 12 хүн хамрагдсанаас 8 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 4 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 297 иргэнийг хамруулж, 15.1 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 93 иргэн орж, шинээр 9 иргэн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 78 иргэний хөдөлмөрийн чадвараа алдалт сунгагдаж, 6 иргэн цуцлагдлаа.

Боловсрол, соёлын чиглэлээр: Багш нарын цахим хэлэлцүүлэг зохион байгуулж 1 дүгээр улиралд судлахаар төлөвлөсөн агуулгыг танхимд судалсан, теле хичээлээр судалсан болон судлаагүй орхигдсон агуулгаар нь ангилж, зайлшгүй судлах бие даан судлах боломжтой агуулгуудыг 2 дугаар улирлын хөтөлбөртөө хэрхэн тусгах талаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хэлэлцүүлгийн хүрээнд суралцагчдын сурлагын хоцрогдлыг арилгах 3 сарын ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг чанартай зохион байгуулах чиглэлийг сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлээ.

“Сайн хичээл” цахим ур чадварын уралдааны 1 дүгээр шатны шалгаруулалтыг сургууль бүр дээр зохион байгууллаа. 2 дугаар шатны шалгаруулалтад нийт 20 судлагдахууны 420 хичээлийг цахим орчинд байршуулж цахим хичээлийн санг бүрдүүлэн багш, сурагчдын суралцах боломжийг бүрдүүлж байна.

Мөн сургуулийн удирдлагуудтай цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж, ажлын чиглэлээ гаргаж, 3 асуудлыг шийдвэрлэлээ.

Нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих, ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажлын хүрээнд нийт сургууль, цэцэрлэг, дотуур байрны ус ариун цэвэр хангамжийн судалгаа, ажлын төлөвлөгөөг гаргаж БШУЯ-д хүргүүлээ.

“Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр” төсөл арга хэмжээний 1 дүгээр шатны хэлэлцүүлгийг цахимаар болон танхимын хэлбэрээр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 860 гаруй багш, удирдах ажилтан, эцэг эхийн төлөөлөл оролцож саналаа солилцлоо.

2021 оны 03 сарын 1-ний өдрөөс эхлэн хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан БШУЯ-аас зохион байгуулсан 1 өдрийн сургалтад холбогдох албан хаагчид оролцон, мэдээлэл авлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан олон нийтэд гэр бүлийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд “Сэтгэл зүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж 35 албан хаагчдыг хамрууллаа. Мөн тус байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж, 3 албан хаагчид сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлээ.

Тайлант хугацаанд аймгийн “Оны онцлох” хүүхдүүдийг шагнаж урамшуулах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Европын холбоо болон Канад сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Бүгд залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө” төслийн хүрээнд “Залуусын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам”-д сайн дурын үйл ажиллагааны оролцогч талуудын саналыг тусгах зөвлөмж боловсруулах нэгдсэн хэлэлцүүлэгт хамрагдан, санал солилцлоо. Мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжил сонголтын ментор хөтөлбөрийг ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж байна. Хөтөлбөрт хамрагдсан нийт сурагчдаас 100 сурагчийг түүврийн аргаар сонгон авч 2 үе шаттай цахим сургалтыг зохион байгуулж байна.

Аймгийн хүүхдүүдийн хөгжил оролцоог сайжруулах, санал санаачилгыг нь дэмжих зорилгоор google form ашиглан аймгийн төвийн ерөнхий боловсролын 5 сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн сурагчдаас авах 18 асуулга бүхий судалгаа боловсруулж, 255 сурагч хамрагдаад байна.

Хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсанд хүүхдийн эрхийн зөрчлийн 2 дуудлага ирж хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан насанд хүрээгүй 2 иргэнд 5 удаагийн 10 цагийн хууль эрх зүй, амьдрах ухааны сургалтыг зохион байгууллаа.

Гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйг түгээн дэлгэрүүлэх, сэтгэл зүйн эрүүл мэндийн чиглэлээр нийт 8 удаагийн мэдээллийг 2653 хүнд хүргэлээ.

Залуучуудын хөгжлийн төвийн пэйж хуудаст цаг үеийн мэдээлэл байршуулж, 500 гаруй иргэнд хүрч ажиллалаа. “Манай гэр бүлийн дүрэм” чөллэнжид залуу гэр бүлүүд идэвхтэй оролцож 5 дахь гэр бүл хамрагдаж, 1200 хүнд хүрсэн байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Дэд бүтэц, уул уурхай, хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын хэмжээг үе шаттайгаар бууруулах” зорилтыг тусган, “Нөхөн сэргээлт -2024” нэгдсэн арга хэмжээг орон нутагт зохион байгуулах дэд ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


2021 онд уул уурхайн олборлолтод өртсөн 22.57 га, дэд бүтцийн 4.35 га, хууль бусаар ашигт малтмал олборлолтод өртсөн 7.9 га талбайд нөхөн сэргээлтийг хийлгэх зорилт тавин ажиллаж байна.

Улсын хэмжээнд түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах 30 байршил тогтоогдсон бөгөөд тус аймгийн Дэлгэр сумын улсын чанартай авто зам дагуу байршлыг тогтоосон болно.

НАЙМ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР


Удирдлага, зохион байгуулалтын талаар: Худалдаа үйлдвэр үйлчилгээний 112, архи согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 66, барааны дэлгүүр 54, ШТС 19, зочид буудал 6, үсчин гоо сайхны 16, харилцаа холбооны 8, спортын үйл ажиллагаа эрхлэгч 8, санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч 3 банк тэдгээрийн салбар, АТМ-г хамруулан 241 объектод 26 үзүүлэлтээр шалгалт хийснээс 86 аж ахуй нэгж байгууллагад гүйцэтгэлийн хяналт хийж зөрчил арилгалт 57.0 хувьтай байна.

Иргэний зорчих хөдөлгөөн тэмдэглэх хянах зорилгоор аймгийн төвийн эмнэлэг, эмийн сан, банк, худалдааны бөөний төв, нийт 30 цэгт QR кодыг байршуулж, 250 зөвлөмж хүргэлээ. Мөн орон нутгийн иргэдийг татан авалттай холбоотой 98 иргэний халдвар хамгааллын байдалд хяналт тавьж ажиллалаа.




 **МОНГОЛ УЛСЫН
ОНЦГОЙ КОМИСС**

БҮРТГЭЛИЙН ЦЭГ

**QR КОДЫГ УНШУУЛЖ КОВИД-19
ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮҮ!**



**ГОВЬ-АЛТАЙ, ЕСӨНБУЛАГ, 7-Р БАГ, ЖИНСТ, ЖИНСТ БАГ, ГОВЬ-АЛТАЙ
АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**

1800-1105

QR КОДЫГ ХЭРХЭН ҮҮСГЭЖ, АШИГЛАХ ТАЛААР

Зорилго:

Засгийн газрын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан бүх шатны албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний төвүүд халдвараас урьдчилан сэргийлэх санхиттай нөхцөл байдал үүссэн тохиолдолд иргэдийн байршилг тогтоох зорилгоор QR код үүсгэж, ажлын байрандаа байршуулсан байх шаардлагатай.

Аж ахуйн нэгжүүд QR код авах:



1. www.qr.119.mn хааг руу орно.
2. Байгууллагын нэр, утас зэрэг шаардлагатай мэдээллийг оруулж QR код үүсгэх товчийг дарж, кодоо авна.



3. QR кодыг байгууллагынхаа үүдэнд наана.


Иргэд QR код уншуулахдаа:

1. Ebarimt аппликейн руу орно. Наярх хэсгийн өмнөх цонхонд COVID-19 цэс харгана.Цэс харгахгүй бол appstore, playstore руу орж. Ebarimt аппликейнээ шинэчлэх шаардлагатай./
2. COVID-19 рүү ороход QR код уншуулах хэсэг гарч ирнэ. Аж ахуйн нэгжийн QR кодыг уншуулна.



Иргэн та зорчих буй хөдөлгөөнөө тэмдэглэснээр халдварын эрсдэл тохиолдоход шуурхай мэдэгдэл хүлээн авч, шинжилгээнд хамрагдан, халдварын тархалтыг бууруулах ач холбогдолтой.

Тус системд иргэний хувийн мэдээлэл бүртгэгддэггүй. Зөвхөн Ebarimt аппликейнээр дамжуулан тухайн иргэний гар утсанд эрсдэлийн тухай мэдэгдэл цаг алдахгүй очно.



Улсын Онцгой комиссын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжаар Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах

зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 18.00 цагаас 02 дугаар сарын 21-ний өдрийг дуустал аймгаас орох, гарах хөдөлгөөний хязгаарлалтыг хэрэгжүүлэхээр 34 албан хаагч ажиллалаа.

МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 01/01 удирдамжийн дагуу 19 сум тосгоны эрүүл мэндийн төв, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн коронавируст халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдалд шалгалт хийж, 136 зөрчил илрүүлэн 87 зөрчлийг газар дээр нь арилгуулан 56 заалттай 8 албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 17 сум, 2 тосгоны тусгаарлан ажиглах байранд хяналт шалгалт хийн 8 сумын Засаг даргын Тамгын газарт бэлэн байдлыг хангуулах талаар албан шаардлага, коронавируст халдварын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуулаар шинжилгээ хийх 20 түр цэгийн үйл ажиллагаанд шалгалт хийн 11 сумын ЗДТГ-т 12 заалттай албан шаардлагыг тус тус хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 23 объект хамрагдан 9 сумд газар дээр нь, 10 сумд цахимаар хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

МХЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан 01/05 дугаар удирдамжийн дагуу хүнсний худалдаа эрхлэгч 53, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн худалдан борлуулж буй 44 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, ил задгай худалдаа эрхэлж байсан 18 иргэний зөрчлийг газар дээр нь арилгууллаа.

Тус хяналтаар 9 иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс дээж авч МХГ-ын дэргэдэх Хими, нян судлалын лабораторид шинжилгээнд хамрууллаа.

Урьдчилан сэргийлэх хяналтаар 95 нэр төрлийн 14.92 кг 621 ширхэг 1881705 төгрөгийн хэрэглээний баталгаат хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч сумдын захиргааны зөвлөлд шилжүүлж устгууллаа.

--	--

Төлөвлөгөөт бус хяналтаар: 3 аж ахуйн нэгж, байгууллага, 1 иргэнээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, барилгын ашиглалтад 5 дүгнэлт гаргаж, 1 иргэнд 12 сарын цалингийн зөрүү 143.8 мянган төгрөгийг олгуулж, ажилгүйдлийн тэтгэмж ажил олгогчоос гаргуулахаар 857.9 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нэгдсэн лаборатори: Лабораторид 9 аж ахуй нэгжээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 12 сорьц 50 үзүүлэлт, ундны усны 4 сорьц 12 үзүүлэлт, арчдас 80 сорьц 80 үзүүлэлтээр хими хор судлал, хорио цээр, нян судлалын шинжилгээг хийж, төлбөрийг бүрэн төвлөрүүллээ.

Үүнээс хүнсний бүтээгдэхүүний 2 сорьц 2 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна.

Дээжийн дугаар	Дээжийн нэр	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ	Үр дүн
145	Хэвийн боов	Тослог	21,0%-иас багагүй	15%
147	Хэвийн боов	тослог	21,0%-иас багагүй	16%

ЕС. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОНЦЛОГ АЖИЛ:

Баян-Уул сум: Сар шинийн цахим мэндчилгээг сумын Соёлын төвийн хамт олон бэлтгэн хүргэж, тус мэндчилгээг 400 очим иргэн үзэж сонирхсон байна. Мөн багийн дарга нарын цахим мэндчилгээг бэлтгэн хүргэж 360 иргэн үзэж сонирхсон. МУСТА Л.Баттогтохын ая Ахмад настан Б.Даваагийн үг “Нутгийн сүлдэндээ өргөх дуу” цахим уралдаан насанд хүрэгчдийн дунд зарлаад байна. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхдүүдэд “Эмээгийн үлгэрийн цаг” арга хэмжээг цахимаар зохион байгууллаа.

Бугат сум: 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдөр сар шинийн баярыг угтаж сумын хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулж гудамж талбай нийтийн эзэмшлийн 1,1 га газрын талбайн хог цэвэрлэж 2 машин 4.0 тн хог цэвэрлэн, хогийн цэгт хүргэж, 120 гаруй иргэд хамрагдлаа.

Тус сумын ернхий боловсролын сургуулийн анги удирдсан багш нар теле хичээл үзэж байгаа сурагчдын судалгааг гаргаж, уг хичээлийг үзэж чадахгүй байгаа сурагчдын хоцрогдлыг арилгах зорилгоор даалгаврын сан бүрдүүлэн хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Соёлын өвийн үндэсний төвөөс улсын хамгаалалтад зэрэглэл ахиулан шилжүүлэх үл хөдлөх дурсгал, аймгийн хамгаалалтад зэрэглэл ахиулан шилжүүлэх үл хөдлөх дурсгалын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг цахимаар хүргүүллээ.

Жаргалан: Багш ажилчид хамтарч ёс заншлын төв байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Сар шинийн баяраар соёлын төвийн албан хаагчид, ардын авьяастнуудын хамтарсан “Энх мэндийн баяр” цахим дуун концерт, мэдчилгээг зохион байгуулж, үзэгчдийн хүртээл болгосон байна. Соёлын төвийн дэргэд төгөлдөр хуурын дугуйлан хичээллэж 7 хүүхэд хамрагдаж байна.

Отроор явж буй малчдад бэлчээр чөлөөлөх мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн.

Тайшир: Тус сумын Галуут багийн нутагт 1 тэмээ галзуу өвчнөөр өвчилсөн шинж тэмдэг илэрч дээжийг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж, онош баталгаажин 2 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосон шийдвэр гаргаж, 241 тэмээг вакцинжуулалтад хамруулсан байна.

Сумын Соёлын төвөөс сар шинийн мэндчилгээг зохион байгуулж, Соёлын тэргүүний ажилтан, ардын авьяастнууд “Уяхан замбуу тивийн наран” дуу, “Үүлэн бор” аязыг морин хуур хөгжмөөр тоглож сумын иргэддээ тус тус мэндчилгээ дэвшүүлсэн байна.

Сумын Номын сангаас зохиолч Билгүүний “Ээлжийн харуул” зохиолыг цахимаар иргэдэд хүргэж, 257 уншигчид үйлчилсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдад гэрээр зөөврийн номын сангаар үйлчилсэн.

Бэлтгэл бүлгийн багш 19 хүүхдэд гарын авлага бэлтгэн хүргэсэн байна.

Цэцэрлэгийн туслах багш, ажилчид хамтран сүүдэр ший, хүүхэлдэйн театр 2 төрлөөр ашиглах боломжтой хэрэглэгдэхүүнийг бэлтгэв.

Цогт: Цэцэрлэгийн 4 бүлгийн хүүхдүүдэд Бага насны цогц хөгжил сэдвээр цахим сургалтыг зохион байгуулж, гарын авлагыг хүүхэд бүрийн гэрээр хүргэсэн бөгөөд сургалтад 110 эцэг эх хамрагдсан байна.

Үндэсний бичгийн гарааны үнэлгээг тогтоож, анхан болон дунд шатны сургалтад нийт 65 багш, ажилчид хамрагдаж байна.

Шарга: Тусгаарлах байрыг шинэчлэн тохижууллаа. Уг тохижилтод сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 1600.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Эрдэнэ сум Малчин өрхийг тамгажуулах ажлын хүрээнд 24 малчны захиалгыг авч тамганы үйлдвэрт хүргүүлсэн.

Сум хөгжлийн сангийн мэдээлэл Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбогдох болсонтой холбоотойгоор 32 зээлдэгчтэй нэг бүрчлэн уулзаж, мэдэгдэх хуудас өгч 3 сарын зээл болон зээлийн хүүг төлүүлсэн.

Сумын Соёлын төв үйл ажиллагаагаа 7 хоногоор төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүүхдийг яаж номд дуртай болгох талаарх “Номонд хөтлөх ухаан” мэдээллийг цахимаар хүргэж байна. Мөн Үндэсний хөгжмийн дугуйлан хичээллүүлж шавь сургалтаар ганцаарчилсан хичээл зохион байгуулж байна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

